

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн  
22/125 тоот тогтоолын Хавсралт 9

**“БОГД БАНК ХК”-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ,  
СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Баримт бичгийн нэр:	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх журам
Хувилбарын дугаар:	1.0
Боловсруулсан нэгж:	ТУЗ-ийн ажлын алба
Хэрэгжилтэд хяналт тавих:	ТУЗ,
Хамаарах нэгж:	ТУЗ, түүний хороод

**Агуулга**

1. Нийтлэг үндэслэл
2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа
3. ТУЗ-ийн гишүүнийг сонгох ажиллагаа
4. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа, гишүүнийг хугацаанаас өмнө чөлөөлөх
5. ТУЗ-ийн гишүүний орон гарсан тохиолдолд орлох гишүүнийг томилох

## Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь компанийн ТУЗ-ийн гишүүдийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлүүдийг гишүүн бүрээр тодорхойлж тодорхойлох, нэр дэвшигчийг олох, сонгон шалгаруулах, нэрийг нь дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх ажиллагааг явуулахтай холбоотой харилцааг зохицуулсан баримт бичиг юм.
- 1.2 Энэхүү журмыг Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монгол банкнаас гаргасан холбогдох журам болон Банкны дүрэм, ТУЗ-ийн ажиллах журам зэрэг барим бичгийн холбогдох заалтуудыг үндэс болгосон болно.
- 1.3 Энэхүү журмыг ТУЗ хуульд заасны дагуу өөрөө батлан хэрэгжүүлнэ.

### Хоёр. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа

- 2.1. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо гардан зохион байгуулах үүрэгтэй бөгөөд энэхүү ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник ажиллагаанд нь компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон компанийн хүний нөөцийн газраас зохих туслалцааг үзүүлнэ.
- 2.2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг тусад нь зохион байгуулна.
- 2.3. **ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нь дараах дарааллаар явагдана:**
  - 2.3.1. ТУЗ-ийн ердийн гишүүний орон гарсан тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо (ийм хороо томилогдоогүй тохиолдолд Гүйцэтгэх захирал)-ноос тухайн ердийн гишүүний төлөөлдөг эрх бүхий этгээд (ТУЗ-д өөрийн төлөөллийг оруулах эрх бүхий этгээд, ихэнх тохиолдолд ХЭ)-д энэхүү гишүүний орон гарсан тухай мэдэгдэж түүний оронд нэр дэвшүүлэх хүнийхээ нэрийг ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлагын талаар Компанийн тухай хуулийн 79.1 болон Банкны тухай хуулийн 32.1-д заасан заалтын шаардлага бүрийг хангаж байгааг нотолсон баримт бичгийн хамт ирүүлэхийг хүссэн албан бичгийг хүргүүлнэ. Энэхүү албан бичигт хариу ирүүлэх хугацааг заасан байна.
  - 2.3.2. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хорооноос ирүүлсэн мэдэгдэл авсан этгээд компанийн ТУЗ-д өөрийг төлөөлөх хүний нэрийг холбогдох нотолгоо, баримт бичгийн хамт мэдэгдэлд заасан хугацаанд компанийн Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороонд ирүүлнэ.
  - 2.3.3. Энэхүү журмын 2.3.2 эсвэл 2.3.3-т заасан саналыг бичгээр гаргах бөгөөд саналд дараах зүйлүүдийг тусгасан байна.. Үүнд:
    - 2.3.3.1. Санал болгож буй нэр дэвшигч бүрийн талаарх бүрэн танилцуулга;
    - 2.3.3.2. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн эцгийн нэр, өөрийн нэр;
    - 2.3.3.3. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо, төрөл, ангилал;
    - 2.3.3.4. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар, гарын үсэг эдгээр болно.
  - 2.3.4. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо ирүүлсэн саналыг хүлээн авч ажлын 15 өдрийн дотор хянан үзэж шаардлага хангасан гэж үзвэл уг нэр дэвшигчийн нэрийг түүний талаар Банкны тухай хуульд заасан холбогдох материалын хамт Монгол банканд зөвшөөрөл авахаар илгээнэ. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь Монгол банкнаас ирүүлсэн хариуг үндэслэн тухайн хүнийг ТУЗ-ийн гишүүнд томилуулахаар ХЭХ-д нэрийг дэвшүүлэх эсэхээ шийдвэрлэнэ.

- 2.3.5. ТУЗ-д өөрийн төлөөллийг оруулах эрх бүхий этгээдээс ирүүлсэн хүн нь зохих шаардлага хангаагүй гэж Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо эсвэл Монгол банк үзсэн тохиолдолд Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь энэ тухайгаа уг санал ирүүлсэн этгээдэд мэдэгдэн дахин шаардлага хангасан хүнийг санал болгох мэдэгдлийг хүргүүлнэ.
- 2.4. **ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нь журмын дагуу явагдана:**
- 2.4.1. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79.1 дэх заалтыг хангасан байхаас гадна Банкны тухай хуулийн 32.1, 33.3-д заасан заалтуудыг хангасан хувь хүн байна.
- 2.4.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг зөвхөн Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо зохион байгуулна. Энэхүү хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаанд компанийн хувьцааны хяналтын багц хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх удирдлага болон төрийн аль нэг албан тушаалтан, байгууллагын зүгээс оролцохыг хориглоно.
- 2.4.3. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгохдоо нэгдүгээрт өөрт байгаа эх сурвалжаас тухайн үед гишүүнд тавьж буй шаардлагыг хангах хүнийг сонгох, хоёрдугаарт өөрт буй эх сурвалжаас тохирох хүн байхгүй байх эсвэл ийм эх сурвалж байгүй тохиолдолд нийтийн сонгон шалгаруулалт зарлан түүнд оролцогчдоос тохирох хүнийг сонгох гэсэн хоёр хэлбэрийн тухайн үед аль тохирох хэлбэрийг сонгон түүнийхээ дагуу хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгоно.
- 2.4.4. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь нэр дэвшигчийг сонгохдоо энэхүү журмын 2.4.1-д заасан хуулиудын холбогдох заалтуудад заасан шаардлагыг удирдлага болгоно.
- 2.4.5. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь өөрийн сонгосон ТУЗ-ийн хараат бус гишүүнд дэвшигчийн нэрийг түүний талаар Банкны тухай хуульд заасан холбогдох материалын хамт Монгол банкинд зөвшөөрөл авахаар илгээнэ. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь Монгол банкнаас ирүүлсэн хариуг үндэслэн тухайн хүнийг ТУЗ-ийн гишүүнд томилуулахаар ХЭХ-д нэрийг дэвшүүлэх эсэхээ шийдвэрлэнэ.

### **Гурав. ТУЗ-ийн гишүүнийг сонгох ажиллагаа**

- 3.1. ХЭХ-аас ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо санал хураах кумлятив аргыг хэрэглэх бөгөөд санал хураалтаар хуралд оролцсон ХЭ-ээс хамгийн олон санал авсан эхний 9 нэр дэвшигч (орон гарсан гишүүнийг томилох тохиолдолд орон гарсан гишүүний тоотой тэнцүү тооны)-ийг ТУЗ-ийн гишүүнээр сонгоно.
- 3.2. ТУЗ-ийн гишүүнийг сонгох хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогч хувьцаа эзэмшигч өөрийн бүх саналаа нэг нэр дэвшигчид өгч болохоос гадна хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгч болно.
- 3.3. Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хорооноос ТУЗ-ийн гишүүнийг сонгох сонгуультай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг дараах мэдээллээр хангасан байна. Үүнд:
- 3.3.1. Нэр дэвшигчийг санал болгож буй этгээдийн нэр
- 3.3.2. Нэр дэвшигчдийн нэр;
- 3.3.3. Нэр дэвшигчдийн нас, боловсрол;
- 3.3.4. Нэр дэвшигчдийн өнгөрсөн таван жилд эрхэлсэн ажлыг нь оролцуулан мэргэжлийн туршлага;
- 3.3.5. Нэр дэвших үед хашиж буй ажил, албан тушаал;

- 3.3.6. Нэр дэвшигчдийн компанитай холбогдсон байдал;
  - 3.3.7. Нэр дэвшигчдийн бусад аж ахуйн нэгжид хашиж буй удирдах болон бусад албан тушаалууд;
  - 3.3.8. Бусад аж ахуйн нэгжийн захирал, бусад албан тушаалд нэр дэвшсэн байдал;
  - 3.3.9. Нэр дэвшигчдийн компанийн охин, хараат компаниудтай холбогдсон байдал;
  - 3.3.10. Нэр дэвшигч болон компанийн голлох гүйцэтгэгч, гэрээлэгчийн хоорондын харилцаа;
  - 3.3.11. Нэр дэвшигчийг ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад цаг завтай эсэх болон бусад нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал;
  - 3.3.12. Нэр дэвшигчийн зүгээс компанийн хүссэн мэдээллийг өгөхөөс татгалзсан байдал зэрэг болно.
- 3.4. Хараат бус гишүүнд нэр дэвшигчийг Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хорооноос санал болгож байгаа тохиолдолд гишүүнд нэр дэвшигчдийг ХЭХ-д шууд оруулан Монгол банкнаас зөвшөөрсөн тохиолдолд сонгож болохоор ХЭХ-аас шийдвэр гаргуулах замаар сонгож болно.

#### **Дөрөв. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа, гишүүнийг хугацаанаас өмнө чөлөөлөх**

- 4.1 Тус компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх Компанийн дүрмэд заасан хугацаагаар тодорхойлогдоно.
- 4.2 ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох, чөлөөлөхөд Монгол банкнаас зөвшөөрөл авна. Гэхдээ Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүний бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгах нөхцөл ялгаатай байна.
- 4.3 ТУЗ-ийн ердийн гишүүний хувьд дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө ХЭХ-аас дуусгавар болгоно. Үүнд:
- 4.3.1 Гишүүн нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон компанийн дүрэм болон ТУЗ-ийн ажиллах журам зэрэгт заасан холбогдох шалгуурыг хангахгүй болсон;
  - 4.3.2 Хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн;
  - 4.3.3 Биеийн эрүүл мэндийн байдал, эсвэл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг ажлаас чөлөөлж өгөх хүсэлт гаргасан;
  - 4.3.4 Хуульд заасан бусад үндэслэл эдгээр болно.
- 4.4 ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд түүнийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоход Монгол банкнаас гаргасан “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмыг үндэс болгон энэхүү журмын 4.3-т зааснаас гадна дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно. Үүнд:
- 4.4.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, аудитын болон эрсдэлийн удирдлагын хорооны хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр жилд 2-оос дээш удаа оролцоогүй;
  - 4.4.2 Хараат бус гишүүн өөрийн ажлын тайланг улирал бүр Монгол банканд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй;
  - 4.4.3 Хараат бус гишүүн өөрийн оролцсон хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо, эрсдэлийн удирдлагын хорооны хуралд оролцсон тухай ажлын тайлангаа хурал болсноос хойш ажлын 14 (арван дөрөв) хоногийн дотор Монголбанканд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй;
  - 4.4.4 Хараат бус гишүүн нь өөрийн ажлын тайланг хагас жил тутам олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй зэрэг болно.

**Тав. ТУЗ-ийн гишүүний орон тоо гарсан тохиолдолд  
орлох гишүүнийг томилох**

- 5.1. ТУЗ-ийн гишүүний орон тоо гарсан гишүүний оронд Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу компанийн ТУЗ-ийн орлох гишүүнийг ХЭ-ийн дараагийн хурлаар томилох нөхцөлтэйгөөр түр хугацаагаар ТУЗ-өөс дараагийн ХЭХ хүртэлх хугацаанд томилж болно.
- 5.2. ТУЗ-өөс томилох ТУЗ-ийн орлох гишүүнд тавих шаардлага нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих шаардлагатай адил байна.
- 5.3. ТУЗ-өөс томилогдсон ТУЗ-ийн орлох гишүүн нь ТУЗ-ийн гишүүний эрх, үүргийг бүрэн эдлэх эрхтэй байна.

oooOooo